ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/140/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 4**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ ........ 4**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ ........ 4**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ ........ 6**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ ........ 7**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ ........ 8**

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 9**

**3.1. Төлбөрийн акт** ........ 9

**3.2. Албан шаардлага** ........ 10

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 16**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.12 № 22

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.МӨНГӨНЦООЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 274, 2025 оны 10 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарын үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоож нэмэгдүүлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 593.1 сая төгрөгөөр өссөн байна. Мөн тайлант онд үндсэн хөрөнгө 166.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь дээд шатны байгууллагаас өгсөн 210.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

4826050076

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймаг дахь Шүүхийн тамгын газар нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гэрээний биелэлтийг 83.8 хувиар үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,925,152.48** | **49,091,699.23** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 16,729,261.00 | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 16,729,261.00 | - |
| **3121** | **Төгрөг** | 16,729,261.00 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 16,729,261.00 | - |
| **33** | **АВЛАГА** | - | 8,777,529.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 973,668.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 7,803,861.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 35,195,891.48 | 40,314,170.23 |
| **354** | **Хангамжийн материал** | 35,195,891.48 | 40,314,170.23 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,158,000.00 | 2,074,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,037,891.48 | 35,255,491.48 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 2,984,678.75 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **645,282,226.24** | **811,568,730.15** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 645,282,226.24 | 811,568,730.15 |
| **392** | **Биет хөрөнгө** | 616,116,476.24 | 724,383,230.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 548,146,366.00 | 567,130,366.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (113,698,189.58) | (130,170,896.09) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 74,000,000.00 | 74,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (47,305,555.51) | (57,638,888.83) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 208,757,330.93 | 242,774,631.54 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (88,148,698.63) | (97,259,618.56) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 62,219,385.79 | 152,455,211.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (28,404,726.76) | (27,458,139.24) |
| 39217 | Ном | 550,564.00 | 550,564.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 29,165,750.00 | 87,185,500.04 |
| 39301 | Програм хангамж | 5,872,000.00 | 5,124,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,426,250.00) | (1,458,999.96) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 24,720,000.00 | 83,520,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **697,207,378.72** | **860,660,429.38** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **13,215,091.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 13,215,091.00 |
| **413** | **Өглөг** | - | 13,215,091.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 5,728,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 7,487,091.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 6,303,300.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 1,183,791.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **697,207,378.72** | **847,445,338.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 697,207,378.72 | 847,445,338.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 279,550,010.60 | 279,550,010.60 |
| 51101 | Өмч: - төрийн | 279,550,010.60 | 279,550,010.60 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 118,253,219.78 | 268,491,179.44 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 118,253,219.78 | 118,253,219.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 150,237,959.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 299,404,148.34 | 299,404,148.34 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **697,207,378.72** | **860,660,429.38** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,654,857,491.46** | **3,292,936,433.37** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **57,116,918.52** | **232,598,812.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 57,116,918.52 | 232,598,812.32 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 47,898,853.68 | 210,856,358.65 |
| 120009 | Бусад орлого | 9,218,064.84 | 21,742,453.67 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,597,740,572.94** | **3,060,337,621.05** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,549,687,115.00 | 2,936,856,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,549,687,115.00 | 2,936,856,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **48,053,457.94** | **123,481,321.05** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 48,053,457.94 | 123,481,321.05 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,635,868,226.07** | **3,138,609,527.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,635,868,226.07** | **3,138,609,527.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,232,632,390.47** | **2,928,215,444.72** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,727,517,795.00** | **2,329,422,005.00** |
| 210101 | Үндсэн цалин | 988,595,915.00 | 1,434,609,524.00 |
| 210102 | Нэмэгдэл | 532,964,205.00 | 640,643,597.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 109,881,421.00 | 113,293,636.00 |
| 210104 | Урамшуулал | 96,076,254.00 | 140,875,248.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **216,747,461.82** | **292,791,780.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 147,550,591.99 | 199,046,593.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,363,567.19 | 23,417,246.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,638,884.13 | 11,982,823.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,638,884.13 | 11,669,023.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,555,534.38 | 46,676,092.62 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,807,520.08** | **44,420,903.78** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,035,632.08 | 7,693,563.63 |
| 210302 | Түлш, халаалт | 38,037,888.00 | 34,601,658.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,734,000.00 | 2,125,682.15 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **83,377,480.64** | **92,789,728.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 31,647,500.00 | 32,674,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,792,590.00 | 24,729,398.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,121,750.64 | 23,059,880.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,512,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 78,360.00 | 76,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,225,280.00 | 12,249,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **38,500,000.00** | **39,491,220.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 36,000,000.00 | 39,491,220.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,447,400.00** | **13,800,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,447,400.00 | 13,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **22,321,879.80** | **16,795,945.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,890,767.00 | 10,293,038.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,183,500.00 | 2,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 143,988.80 | 90,883.20 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,462,000.00 | 2,896,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 165,624.00 | 165,624.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **85,912,853.13** | **98,703,862.62** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,782,000.00 | 10,693,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 80,130,853.13 | 88,009,962.62 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **403,235,835.60** | **210,394,083.20** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **217,880,370.00** | **101,629,049.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 106,082,000.00 | 67,784,142.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 109,798,977.00 | 33,244,907.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,999,393.00 | 600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **185,355,465.60** | **108,765,034.20** |
| КТ(261090) | Төвлөрүүлэх шилжүүлэг | 185,355,465.60 | 108,765,034.20 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **18,989,265.39** | **154,326,905.45** |
| 225 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 4,088,945.79 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 4,088,945.79 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (4,088,945.79) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **18,989,265.39** | **150,237,959.66** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,607,540,572.94** | **3,060,337,621.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,800,000.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,800,000.00 | - |
| 120009 | Бусад орлого | 9,800,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,597,740,572.94** | **3,060,337,621.05** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,549,687,115.00 | 2,936,856,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,549,687,115.00 | 2,936,856,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,053,457.94 | 123,481,321.05 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 48,053,457.94 | 123,481,321.05 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,571,750,872.94** | **3,050,602,682.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,571,750,872.94** | **3,050,602,682.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,168,515,037.34** | **2,832,404,737.85** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,737,317,795.00 | 2,330,395,673.00 |
| 210101 | Үндсэн цалин | 988,595,915.00 | 1,434,609,524.00 |
| 210102 | Нэмэгдэл | 542,764,205.00 | 640,643,597.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 109,881,421.00 | 113,398,636.00 |
| 210104 | Урамшуулал | 96,076,254.00 | 141,743,916.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **216,747,461.82** | **292,791,780.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 147,550,591.99 | 199,046,593.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,363,567.19 | 23,417,246.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,638,884.13 | 11,982,823.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,638,884.13 | 11,669,023.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,555,534.38 | 46,676,092.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,807,520.08** | **44,420,903.78** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,035,632.08 | 7,693,563.63 |
| 210302 | Түлш, халаалт | 38,037,888.00 | 34,601,658.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,734,000.00 | 2,125,682.15 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **90,139,980.64** | **93,187,106.75** |
| 210401 | Бичиг хэрэг | 34,834,400.00 | 24,582,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,792,590.00 | 27,714,076.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,121,750.64 | 23,059,880.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,512,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 78,360.00 | 76,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,800,880.00 | 17,753,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,530,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,530,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **38,500,000.00** | **39,153,220.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 36,000,000.00 | 39,153,220.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,447,400.00** | **8,410,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,447,400.00 | 8,410,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,242,879.80 | 13,352,154.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,890,767.00 | 7,529,247.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,183,500.00 | 2,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 143,988.80 | 90,883.20 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,383,000.00 | 2,216,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 165,624.00 | 165,624.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,782,000.00 | 10,693,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,782,000.00 | 10,693,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **403,235,835.60** | **218,197,944.20** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 217,880,370.00 | 101,629,049.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 106,082,000.00 | 67,784,142.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 109,798,977.00 | 33,244,907.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,999,393.00 | 600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **185,355,465.60** | **116,568,895.20** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 185,355,465.60 | 116,568,895.20 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **35,789,700.00** | **9,734,939.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **31,771,700.00** | **26,464,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **31,771,700.00** | **26,464,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 31,771,700.00 | 26,464,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 31,771,700.00 | 26,464,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(31,771,700.00)** | **(26,464,200.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 4,018,000.00 | (16,729,261.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 12,711,261.00 | 16,729,261.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 16,729,261.00 | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 279,550,010.60 | 299,404,148.34 | 99,263,954.39 | 678,218,113.33 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **279,550,010.60** | **299,404,148.34** | **99,263,954.39** | **678,218,113.33** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 18,989,265.39 | 18,989,265.39 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,550,010.60** | **299,404,148.34** | **118,253,219.78** | **697,207,378.72** |
| D01 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,550,010.60** | **299,404,148.34** | **118,253,219.78** | **697,207,378.72** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **279,550,010.60** | **299,404,148.34** | **118,253,219.78** | **697,207,378.72** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 150,237,959.66 | 150,237,959.66 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,550,010.60** | **299,404,148.34** | **268,491,179.44** | **847,445,338.38** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,936,856,300.00** | **2,828,091,265.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,936,856,300.00** | **2,828,091,265.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,835,227,100.00** | **2,726,462,216.80** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,336,260,500.00** | **2,220,658,569.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,380,706,700.00 | 1,434,609,524.00 |
| 210102 | Нэмэгдэл | 597,382,400.00 | 530,906,493.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 157,723,300.00 | 113,398,636.00 |
| 210104 | Урамшуулал | 200,448,100.00 | 141,743,916.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **292,032,500.00** | **279,047,563.07** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 198,582,100.00 | 189,713,955.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,362,600.00 | 22,319,288.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,681,300.00 | 11,414,096.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,681,300.00 | 11,120,044.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 46,725,200.00 | 44,480,177.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **50,626,800.00** | **44,420,903.78** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,973,000.00 | 7,693,563.63 |
| 210302 | Түлш, халаалт | 35,672,400.00 | 34,601,658.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,981,400.00 | 2,125,682.15 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **71,892,700.00** | **93,187,106.75** |
| 210401 | Бичиг хэрэг | 24,181,300.00 | 24,582,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,017,100.00 | 27,714,076.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,000,500.00 | 23,059,880.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100.00 | 76,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,693,700.00 | 17,753,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **62,183,100.00** | **65,617,420.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,480,300.00 | 7,480,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 54,702,800.00 | 58,137,220.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,110,100.00 | 8,410,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,110,100.00 | 8,410,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,352,700.00** | **13,352,154.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,529,500.00 | 7,529,247.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,500.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,900.00 | 90,883.20 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,100.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,216,100.00 | 2,216,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 165,600.00 | 165,624.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,768,600.00** | **1,768,500.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,768,600.00 | 1,768,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **101,629,200.00** | **101,629,049.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **101,629,200.00** | **101,629,049.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 67,784,100.00 | 67,784,142.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 33,245,000.00 | 33,244,907.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,100.00 | 600,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,936,856,300.00** | **2,828,091,265.80** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,936,856,300.00** | **2,828,091,265.80** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,936,856,300.00 | 2,828,091,265.80 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **35** | **35** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 16 | 16 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 9 | 9 |

| | | | |
|---|---|---|---|
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10 | 10 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **123,481,321.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **123,481,321.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 123,481,321.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 109,737,104.00 |
| 210102 | Нэмэгдэл | 109,737,104.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 13,744,217.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,332,638.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,097,957.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 568,727.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 548,978.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,195,914.88 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **123,481,321.05** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **123,481,321.05** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 123,481,321.05 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,576.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 6,405.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,391.3 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага, 2,780.0 төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт **6,405.0** мянган төгрөгийн 2 алдаа[1] илрүүлснийг аудитын явцад залрууллаа.

1. Санхүүгийн тайланд ажиллагсадтай холбоотой хоолны хөнгөлөлтийн **105.0** мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.

2. Санхүүгийн тайлан дахь хувь хүмүүст өгөх **6,300.0** мянган төгрөгийн өр төлбөрийг буруу тооцож, илүү тайлагнасан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д *(холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах),* 20.2.4-д *(Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах")* заалтыг зөрчиж мөн "Иж бүрэн" байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 5,171.3 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 2,780.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2,391.3 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 3.1. Төлбөрийн акт

3.1.1. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн гишүүдэд үндсэн цалингийн 20 хувтай тэнцэх хэмжээний урамшуулал **2,780.0** мянган төгрөгийг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.- д (*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах),* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2- т *(төсвийн байгууллага, түүний албан тушаалтан;),* 3.2 -т *(Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.)*, 4 дүгээр зүйлийн 4.1-т (*Хэмнэлтийн горим*

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална)*, 4.1.6-д (*сахилга баттай байх*), 10.2-т (*Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно)* заалтыг тус тус зөрчсөн.

## 3.2. Албан шаардлага

***Зөрчил арилгуулах албан шаардлага***

3.2.1. Санхүүгийн тайлан дахь **2,391.3** мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д *(дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;)*, мөн хуулийн 20.2.6-д *(эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах)* заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 5,171.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 6.1 дахин бага тул **“ӨӨРЧЛӨЛТГҮЙ”** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл :**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажиллагсадтай холбоотой хоолны хөнгөлөлтийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй. | 1 | 105.0 | 1 | 105.0 | | | 1 | 105.0 | | | | |
| Санхүүгийн тайлан дахь хувь хүмүүст өгөх өр төлбөрийг буруу тооцож, илүү тайлагнасан. | 1 | 6,300.0 | | | 1 | 6,300.0 | 1 | 6,300.00 | | | | |
| **Дүн** | **2** | **6,405.0** | **1** | **105.0** | **1** | **6,300.0** | **2** | **6,405.0** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд үндсэн цалингийн 20 хувтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон. | 1 | 2,780.0 | 1 | 2,780.0 | | | | | | | | |
| Санхүүгийн тайлан дахь байгуулагад төлөх урсгал зардлын өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. | 1 | 2,391.3 | | | 1 | 2,391.3 | | | | | | |
| **Нийт дүн** | **2** | **5,171.3** | **1** | **2,780.0** | **1** | **2,391.3** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |